

Үндэсний хөгжлийн газрын даргын  
2020 оны 06 сарын 18 өдрийн 145 тоот  
тушаалын 2.1.3 хэсэг хавсралт

## УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ, ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ АРГАЧЛАЛ

УХА0588  
6098177  
1116127253

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам" болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан энэхүү аргачлал нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /цаашид "УХОХ" гэх/-ийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад чиглэгдэнэ.
- 1.2. УХОХ-т тусгах төсөл, арга хэмжээ /цаашид "төсөл" гэх/-г үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавихад уг аргачлалыг мөрдөх ба уг хөтөлбөрт тусгах төслийн үнэлгээний цахим систем /цаашид "цахим систем" гэх/-ийн үндсэн шийдэл, системийн бизнес загвар байдлаар ашиглагдана.
- 1.3. Аливаа хөрөнгө оруулалтын төслийг энэхүү аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэн, сонгоогүй нь уг төслийг УХОХ-т тусгахгүй байх үндэслэл болно.

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
  - 2.1.1 "улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй" гэж улсын төсвөөс хөрөнгө оруулалтын зориулалтаар төсвийн ерөнхийлөн захирагч нар хуваарилсан төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, мөн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй аливаа зээллэг, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, Засгийн газрын баталгааг;
  - 2.1.2 "төсөл" гэж Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг;
  - 2.1.3 "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;
  - 2.1.4 "ажлын хэсэг" гэж энэхүү аргачлалын дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үүрэг бүхий төсвийн ерөнхийлөн захирагч нарын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүд болон холбогдох бусад эрх бүхий этгээдээс бүрдсэн бүтцийг;
  - 2.1.5 "салбарын стандарт үзүүлэлт" гэж төслийн зардал, үр ашгийн тооцоонд ашиглагдах, тухайн төслийн нийгэм, эдийн засгийн үр ашгийг хэмжих салбарын стандарт үзүүлэлтийг;
  - 2.1.6 "нэгдмэл нэг төсөл" гэж үйл ажиллагаа нь бие даан хэрэгжих боломжгүй, салшгүй бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн төсөл, арга хэмжээг;

## ГУРАВ. ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ, ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1. УХОХ-т тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа нь “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”, “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах аргачлал” болон бусад холбогдох аргачлалын дагуу бэлтгэсэн төслийн санал, түүнтэй холбоотой бусад тооцоо судалгаа, мэдээ, мэдээлэл, нотлох баримтад үндэслэнэ.
- 3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн ирүүлж буй төслийн санал, тооцоо судалгаа, мэдээ, мэдээлэл, нотлох баримтын үнэн зөв, бодитой байдлыг бүрэн хариуцна.
- 3.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь УХОХ-т тусгах төслийн саналыг энэ аргачлалын дагуу үнэлж, өөрийн үнэлгээний дүгнэлт, эрэмбийн хамт ирүүлнэ.
- 3.4. УХОХ-т тусгах хөрөнгө оруулалтын төслийг үнэлэн, эрэмбийг тогтоох албан хаагч нь шударга, хариуцлагатай, ил тод, ёс зүйтэй байж, гагцхүү нотлох баримтад үндэслэн мэргэжлийн түвшинд ажиллана.

## ДӨРӨВ. ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ, ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЕ ШАТ, ДАРААЛАЛ

- 4.1. УХОХ-т тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа нь хоёр хэсэгтэй байх ба эхний хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагч төслийн саналаа боловсруулахдаа төсөл тус бүрийг үнэлж, өөрийн салбарын түвшинд төслийн эрэмбийг тогтоон ирүүлнэ. Хоёрдугаар хэсэгт Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төслүүдийг үнэлж, эрэмбэлэн, сонголт хийж, хөтөлбөрийг эцэслэн боловсруулна эсхүл тодотгоно.
- 4.2. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төслүүдийг үнэлж, эрэмбэлэхдээ энэ аргачлалыг мөрдлөг болгох ба УХОХ-т тусгах төслийн сонголтыг хийхдээ Төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн үнэлгээ, эрэмбийг харгалзан үзэж, тэдэнтэй харилцан зөвшилцсөн байна.
- 4.3. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг дараах үе шатуудаар гүйцэтгэнэ. Үүнд:
  - 4.3.1. **Үе шат 1.** Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн материалын иж бүрдлийг Хавсралт 1-ийн дагуу нягтлан, материал дутуу байвал үнэлгээ хийхээс татгалзаж, энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл нэмэлтээр ирүүлэхийг хүсэж нөхөн бүрдүүлэлт хийнэ.
  - 4.3.2. **Үе шат 2.** Төслийн саналыг ирүүлэхдээ “Төслийн саналын маягт”-ыг холбогдох аргачлалын дагуу бүрэн бөглөсөн эсэхийг Хавсралт 2-ын дагуу бүрэн бөглөсөн эсэхийг нягтална. Төслийн саналын маягтуудад хариулсан асуултын тоо нь нийт асуултын 50 хувьд хүрэхгүй байвал үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл хангалтгүй гэж үзэн уг төслийг үнэлэхээс татгалзаж, энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл гүйцээн ирүүлэхийг хүснэ.
  - 4.3.3. **Үе шат 3.** Төслийн саналын маягтууд дахь мэдээлэл нь чанарын шаардлага хангаж буй эсэх өөрөөр хэлбэл ирүүлсэн мэдээлэл нь утга, найруулга, үг хэллэгийн хувьд тухайн төслийн талаар хангалттай мэдээлэл өгөхүйц байгаа эсэх, асуултын утгыг зөв ойлгон бүрэн хариулсан эсэх, хариултауд нь мэдээллийн зөрүүтэй байгаа эсэхийг асуулт нэг бүрээр Хавсралт 2-ын дагуу тодорхойлно.
  - 4.3.4. Хэрэв 4.3.3-д заасны дагуу нягталж үзэхэд чанарын шаардлага хангаж буй мэдээлэл нь нийт ирүүлсэн мэдээллийн 50-д хүрэхгүй бол уг төслийг

үнэлэхээс татгалзаж энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл шаардлагатай тохиолдолд санал ирүүлэгчээс нэмэлт тодруулга авах, зөрүүтэй болон ойлгомжгүй мэдээллийг засуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэн мэдээллийн чанарыг сайжруулж, үнэлэх боломжтой болгоно.

- 4.3.5. **Ye шат 4.** Төслүүдийн "Урьдчилсан үнэлгээ"-г Хавсралт 3-т заасан маягтын дагуу хийнэ. Энэхүү үнэлгээнээс төслийг а. иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, нэн тэргүүнд хэрэгжүүлэх б. иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, хасах в. иж бүрэн үнэлгээний шатанд шилжүүлэх гэсэн 3 ангилалд хуваан Хавсралт 4-т үзүүлсэн маягтын дагуу нэгдсэн дүгнэлт гарган, баталгаажуулна.
- 4.3.6. **Ye шат 5.** "Урьдчилсан үнэлгээ"-ны шатнаас иж бүрэн үнэлгээний шатанд шилжүүлэхээр шийдвэрлэсэн төслүүдэд энэхүү аргачлалын Тав дахь хэсэгт заасны дагуу "Иж бүрэн үнэлгээ" хийнэ.
- 4.3.7. **Ye шат 6.** Урьдчилсан болон иж бүрэн үнэлгээний шатны үр дүнд үндэслэн энэхүү аргачлалын Зургаа дахь хэсэгт заасны дагуу төслийг эрэмбэлнэ.
- 4.3.8. **Ye шат 7.** Төслийн эрэмбийн үр дүнд үндэслэн энэхүү аргачлалын Зургаа дахь хэсэгт заасны дагуу УХОХ-т тусгах төслийг сонгон Хавсралт 8-д заасан маягтын дагуу нэгдсэн тайлан гарган, баталгаажуулна.

## **ТАВ. УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ ТӨСЛИЙН ИЖ БҮРЭН ҮНЭЛГЭЭ**

- 5.1. Төслийн иж бүрэн үнэлгээ нь төслийн төлөвлөлт, бэлтгэл хангалт, явц, хэрэгжих боломж болон тухайн төслийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, ач холбогдлыг нотолгоонд суурилан үнэлэх зорилготой.
- 5.2. Төслийн иж бүрэн үнэлгээ нь а. Төсвийн ерөнхийлөн захирагч, б. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэсэн хоёр талын бие даасан үнэлгээнээс тогтоно.
- 5.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлалыг ашиглах гарын авлага"-ын дагуу Хавсралт 5-д үзүүлсэн маягтаар төсөл нэг бүрээр үнэлгээ хийх ба уг үнэлгээндээ үндэслэн энэ аргачлалын Зургаа дахь хэсэгт заасны дагуу өөрийн хариуцах асуудлын хүрээнд хамаарах төслүүддээ эрэмбэ тогтоон хүргүүлнэ.
- 5.4. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү аргачлалын 4.3.5-д заасан "Урьдчилсан үнэлгээ"-ээс "иж бүрэн үнэлгээний шатанд шилжүүлэх" ангилалд багтсан төслүүдэд "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлалыг ашиглах гарын авлага"-ын дагуу Хавсралт 6-д үзүүлсэн маягтаар үнэлгээ хийнэ.
- 5.5. Төслийн иж бүрэн үнэлгээ хийх арга зүй нь төслийг а. Ач холбогдол, б. Хэрэгжих боломж гэсэн 2 ерөнхий шалгуур үзүүлэлтээр үнэлж, оноо өгөх арга байна. Ерөнхий шалгуур үзүүлэлт тус бүр 6, нийт 12 үндсэн шалгуур үзүүлэлт, 42 дэд шалгуур үзүүлэлтээс бүрдэнэ.
- 5.6. Ерөнхий шалгуур үзүүлэлт нь УХОХ-т тусгах төсөлд тавигдах үндсэн нөхцөл бөгөөд хөгжлийн бодлогын хүрээнд төслийн ач холбогдол, хэрэгжих боломж, төслийн төлөвлөлт, үр дүнг үнэлэх зорилготой.
  - 5.6.1. Ач холбогдол: Хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангахад чиглэсэн эсэх, тухайн төслийн нийгэм, эдийн засаг, бүс орон нутгийн хөгжил, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө, бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал, тэдгээрийн харилцан нөлөөллийг үнэлэх зорилготой.

- 5.6.2. Хэрэгжих боломж: Тухайн төслийн төлөвлөлт, шийдэл, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, төслийг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан байдлыг үнэлэх зорилготой.
- 5.7. Төслийг дээрх 2 ерөнхий шалгуурын хүрээнд тодорхойлогдсон дараах 12 үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлнэ. Үүнд:
- 5.7.1. Төслийн ач холбогдлыг тодорхойлох үндсэн шалгуур үзүүлэлтүүд
- а. Үндсэн шалгуур үзүүлэлт 1.1. Хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэх байдал. УХОХ-т тусгах төсөл нь улс, салбар, бүс, орон нутгийн хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд туссан тодорхой зорилго, зорилтыг хангахад чиглэсэн байна. Эсхүл бодлогын тодорхой зорилго, зорилттой уялдахгүй боловч "яаралтай эсхүл зайлшгүй" хэрэгжүүлэх шаардлага үүссэн нь тогтоогдсон байна.
- б. Үндсэн шалгуур үзүүлэлт 1.2. Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал. Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын зорилго, зорилтыг хангаж, залгамж чанарыг дээшлүүлэхэд төсөл, арга хэмжээний уялдааг хангах шаардлагатай тул хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг уялдуулж, нэгдсэн байдлаар төлөвлөсөн байна.
- в. Үндсэн шалгуур үзүүлэлт 1.3. Нийгмийн ач холбогдол. Төсөл, арга хэмжээ нь дор дурдсан шаардлагыг хангасан, нийгмийн ач холбогдол, эерэг нөлөөлөл нь нотлогдсон байна:
- төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартыг сайжруулах;
  - хүний эрүүл, урт удаан амьдрахад нөлөөлөх;
  - иргэдийн мэдлэг, боловсролын түвшин дээшлүүлэх;
  - иргэдийн эрүүл, аюулгүй, зохистой орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;
  - үндэсний үнэт зүйлийг хадгалах, хамгаалах, бий болгох;
  - Зардал үр ашгийн тооцоонд дурдагдсан нийгмийн ач холбогдлын үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшнийг хангасан;
- г. Үндсэн шалгуур үзүүлэлт 1.4. Эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж. Төсөл, арга хэмжээ нь дор дурдсан шаардлагыг хангасан, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжтэй болох нь нотлогдсон байна:
- үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх;
  - экспортыг дэмжих, импортыг орлох;
  - ажлын байрыг нэмэгдүүлэх;
  - иргэдийн цалин, бодит орлогыг нэмэгдүүлэх;
  - гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
  - ЗҮАТ-нд дурдагдсан эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын огоожийн үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшнийг хангасан.
- д. Үндсэн шалгуур үзүүлэлт 1.5. Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө. Төсөл, арга хэмжээ нь хүрээлэн буй орчинд ээлтэй технологийн шийдэлтэй, хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын тогтолцоог нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхээр төлөвлөсөн байх шаардлагатай ба энэ нь холбогдох судалгаагаар нотлогдсон байна.
- е. Үндсэн шалгуур үзүүлэлт 1.6. Бүс, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө. Төсөл, арга хэмжээ нь бүс, орон нутгийн эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэсэн нь тогтоогдсон, нөлөөллийг холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн байна.
- 5.7.2. Төслийн хэрэгжих боломжийг тодорхойлох үндсэн шалгуур үзүүлэлтүүд
- а. Үндсэн шалгуур үзүүлэлт 2.1. Хууль, эрх зүйн орчин. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хууль, журам, дүрэм, тогтоол зэрэг хууль эрх зүйн актууд бүгд батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эсэх, төсөл хэрэгжүүлэх холбогдох тушаал, шийдвэр гарсан эсэхээр үнэлнэ.

б. Үндсэн шалгуур үзүүлэлт 2.2. Дэд бүтцийн хүрэлцээ. Төсөл, арга хэмжээний дэд бүтцийн бэлэн байдлыг дэд бүтэц байгуулах нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай эсэхээр үнэлнэ.

в. Үндсэн шалгуур үзүүлэлт 2.3. Төслийн бэлтгэл хангагдсан эсэх. Төслийн санал гаргахаас өмнөх төлөвлөлтийн шатанд дор дурдсан судалгаа, шинжилгээг хийж, шаардлагатай зохицуулалтын арга хэмжээг авсан байна.

- ТЭЗҮ, ЗҮАТ, БОНБУ, Эрсдэлийн шинжилгээ болон бусад шаардлагатай судалгаа, шинжилгээг хийсэн байх;
- Төслийг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах нэгжийг байгуулсан байх;
- Төсөл хэрэгжүүлэх газрын бэлэн байдал, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авсан, ашиг сонирхол нь хөндөгдөх холбогдох талуудтай зөвшилцөлд хүрсэн байх.

г. Үндсэн шалгуур үзүүлэлт 2.4. Төлөвлөлт, шийдлийн хувьд хэрэгжих боломжтой эсэх. Төсөл боловсруулагч нь дараах шаардлагыг хангасан төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна.

- Зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, жил бүрийн хүрэх;
- Түвшин тодорхой, ойлгомжтой, хэмжиж болохуйц байдлаар тодорхойлсон;
- Төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны үе
- шатуудад ажлын цар хүрээг зорилготой уялдуулан тодорхойлсон, хэрэгжих цаг хугацааг тодорхой тусгасан;
- Төсөлд ашиглаж буй техник, технологийн мэдээллийг тусгасан.

д. Үндсэн шалгуур үзүүлэлт 2.5. Санхүү, эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой эсэх. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд санхүүгийн чадамжийн талаар дараах үзүүлэлтийг нарийвчлан тусгасан байх шаардлагатай.

- Төслийн санхүүжилтийн эх үүсвэр;
- Төслийн өртөг, орлого, зарлага болон бусад шаардлагатай санхүүгийн үзүүлэлтүүд;
- Хөрөнгө оруулалтын өгөөж

е. Үндсэн шалгуур үзүүлэлт 2.6. Эрсдэлийн түвшин. Төсөл, арга хэмжээний эрсдэлийг тодорхойлж, түүнээс сэргийлэх, шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан байх шаардлагатай. Төслийн эрсдэлийн түвшнийг "Хөрөнгө оруулалтын төслийн эрсдэлийн шинжилгээ хийх аргачлал"-ыг ашиглан үнэлнэ.

- 5.8. Төслийг үнэлэх дээрх шалгуур үзүүлэлтүүд нь Хавсралт 9, 10-т үзүүлсэн "Үндсэн шалгуур үзүүлэлт", "Дэд шалгуур үзүүлэлт", "Жишиг үзүүлэлт"-ээс бүрдэнэ.
- 5.9. Ач холбогдол хэсэгт Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Хавсралт 9, 10-с гадна Хавсралт 11-д үзүүлсэн бие даасан үнэлгээний "Дэд шалгуур үзүүлэлт"-ээр үнэлгээ хийнэ. Энэ нь үндэсний хөгжлийн бодлогын хүрээнд салбар, бүс, орон нутаг хоорондын уялдааг хангах, төслийн ач холбогдлыг энэхүү өнцгөөс тодорхойлж, үнэлэх зорилготой.
- 5.10. Төслийн иж бүрэн үнэлгээг дор дурдсан дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:
- 5.10.1. Чухал ач холбогдолтой, бодлогын уялдааг харгалзан өөрчлөгдөх магадлал багатай зарим нэг шалгуур үзүүлэлтийг тодотгох зорилгоор хувийн жинг тогтоосон. Бодлогын уялдаа нь үнэлгээг хийснээс хойш төсөл хэрэгжих явцад гарах өөрчлөлт бага гэж тооцож байгаа бөгөөд нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр нөлөө нь өөрчлөгдөх эрсдэл ихтэй хэдий ч бодит байдал дээр бодлогын уялдаатай холбогдох тул хувийн жинг өндрөөр тогтоосон.

- 5.10.2. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бие даасан үнэлгээ дээр “Хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцсэн байдалд” хувийн жинг өндөр тогтоосон.
- 5.10.3. Дэд шалгуур үзүүлэлт тус бүрийг 3 хүртэлх оноогоор үнэлнэ.
- 5.10.4. “Ач холбогдол” болон “Хэрэгжих боломж” гэсэн ерөнхий шалгуур үзүүлэлт тус бүрээр Үнэлэгдсэн онооны нийлбэрийг тооцно.
- 5.10.5. Ерөнхий шалгуур үзүүлэлт тус бүрээр Үнэлэгдсэн онооны нийлбэрийг авбал зохих дээд онооны нийлбэрт харьцуулж, авбал зохих онооны хэдэн хувиар үнэлэгдсэнийг тодорхойлно.
- 5.10.6. Аргачлалын 5.10.4-т дурдсан үнэлгээнд үндэслэн ерөнхий шалгуур үзүүлэлт тус бүрийг үсгэн үнэлгээгээр үнэлэх ба энэ нь төслийг эрэмбэлэхэд баримтлах үндсэн үзүүлэлт болно.

| Ач холбогдол                  |               | Хэрэгжих боломж               |               |
|-------------------------------|---------------|-------------------------------|---------------|
| Авбал зохих оноонд эзлэх хувь | Үсгэн үнэлгээ | Авбал зохих оноонд эзлэх хувь | Үсгэн үнэлгээ |
| 80-аас дээш                   | А             | 80-аас дээш                   | А             |
| 65%-80%                       | В             | 65%-80%                       | В             |
| 65%-аас доош                  | С             | 65%-аас доош                  | С             |

- 5.10.7. Төслийн үнэлгээг хийж дууссан гэж үзвэл Хавсралт 7-д үзүүлсэн маягтын дагуу Иж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлтийг гаргаж, баталгаажуулна.

#### **ЗУРГАА. УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ ТӨСЛИЙГ ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ**

- 6.1. Төслийг эрэмбэлэхдээ а. Урьдчилсан үнэлгээний дүгнэлт, б. Төслийн иж бүрэн үнэлгээ, в. Иж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлт зэргийг харгалзана.
- 6.2. Төслийн “Урьдчилсан үнэлгээ”-ний дүгнэлтийн “Нэн тэргүүнд хэрэгжүүлэх төслүүд” гэсэн ангилалд багтсан төслүүдийг Нэгдүгээрт эрэмбэлэх ба энэхүү багцад хамаарах төслүүдийн дарааллыг эрх бүхий албан тушаалтны саналаар тодорхойлно.
- 6.3. Төслийн “Иж бүрэн үнэлгээний дүгнэлт”-д үндэслэн төслүүдийг эрэмбэлж, сонголт хийхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:
- 6.3.1. “Ач холбогдол” болон “Хэрэгжих боломж” гэсэн ерөнхий шалгуур үзүүлэлт тус бүр дээр авсан үсгэн үнэлгээний хослолоор төслүүдийн багц үүсгэнэ.
- 6.3.2. Багцуудыг дараах байдлаар эрэмбэлнэ.

| Багцын эрэмбэ | Үсгэн үнэлгээ – “Ач холбогдол” | Үсгэн үнэлгээ - “Хэрэгжих боломж” |
|---------------|--------------------------------|-----------------------------------|
| 1             | А                              | А                                 |
| 2             | А                              | В                                 |
| 3             | В                              | А                                 |
| 4             | В                              | В                                 |
| 5             | А                              | С                                 |
| 6             | В                              | С                                 |
| 7             | С                              | А                                 |
| 8             | С                              | В                                 |
| 9             | С                              | С                                 |

- 6.3.3. Багц доторх төслийн дарааллыг тогтоохдоо тухайн төслийн Үнэлэгдсэн онооны нийлбэр /2 ерөнхий шалгуур үзүүлэлтийн онооны нийлбэр/-т үндэслэнэ.
- 6.3.4. Хэрэв Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гаргасан төслийн "Иж бүрэн үнэлгээний дүгнэлт"-ийн оноо ба эрэмбэ нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн ирүүлснээс зарчмын томоохон зөрүүтэй /50-аас дээш хувийн/ гарсан бол эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулсан зөвшилцөх уулзалт хийн, уулзалтын үр дүнгээр шийдвэрлэнэ.
- 6.4. Зөвшилцсөн үсгэн үнэлгээгээр ерөнхий шалгуур үзүүлэлтийн үнэлгээ нь хоёулаа "С" буюу 9-р эрэмбийн багцаас бусад багцын төслүүдийг УХОХ-т тусгана.
- 6.5. Хэрэв эдгээр төслүүд нь Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн хүрээний мэдэгдэл болон гадаад өрийн зохистой түвшинтэй нийцээгүй бол нийцтэл нь багц 8, багц 7 гэх мэтээр урагшлуулан хасна.
- 6.6. Урьдчилсан үнэлгээний дүгнэлтээр хасагдсан болон Иж бүрэн үнэлгээний үр дүнгээр Ө р багцад хямаарян хасагдаж байгаа төслүүдийг УХОХ-т тусгахгүй хассан тухай мэдэгдлийг холбогдох тайлбар болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналын хамт холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.
- 6.7. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төслийн эрэмбэ тогтоон, сонголт хийсэн эцсийн дүгнэлтийг Хавсралт 8-д үзүүлсэн маягтын дагуу нэгтгэж, эрэмбэ тогтоон, сонголт хийсэн албан хаагчид болон Эрх бүхий албан тушаалтан баталгаажуулна.
- 6.8. Баталгаажсан дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагчид руу албан бичгээр илгээн саналыг авах ба хэрэв Төсвийн ерөнхийлөн захирагч өөр саналтай байвал тухайн Төсвийн ерөнхийлөн захирагч болон эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулсан зөвшилцөх уулзалт хийн, уулзалтын үр дүнгээр шийдвэрлэнэ.

#### **ДОЛОО. УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУССАН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ДАХИН ҮНЭЛЭХ**

- 7.1. УХОХ-г боловсруулах эсхүл тодотгол хийхдээ шилжин хэрэгжих төслүүдийн хэрэгжилтийн явцыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай.
- 7.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах аргачлал" дахь "Төслийн санал"-ын 10 дугаар хавсралтад үзүүлсэн маягтын дагуу төслийн хэрэгжилтийн явц болон төслийг хэрэгжүүлэхэд учирч буй гаяц, бүрхшлэл, эрсдэлт хүчин оүйлоийн талаарх мэдээллийг Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.
- 7.3. Аргачлалын 7.2-ын дагуу мэдээлэл ирүүлэхдээ а.төсөл хэрэгжиж дууссан буюу төслийн хүрээнд дэвшүүлсэн зорилтууд хангагдсан, б.төсөл хэвийн үргэлжилж байгаа буюу үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, в.төсөл төлөвлөгөөний дагуу хэрэгжих эсэх нь эргэлзээтэй буюу дахин үнэлэх шаардлагатай гэсэн ангиллын аль нэгд хамруулж, дүгнэлтийг тайлбарын хамт ирүүлнэ.
- 7.4. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь а.УХОХ-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий бүтцийн нэгжийн ирүүлсэн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, б.7.3-т дурдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн дүгнэлт, в.төслийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлтэй биечлэн танилцсан ажлын дүгнэлт, г.тухайн төсөл, арга хэмжээг хариуцсан гүйцэтгэгч, захиалагч байгууллагын мэдээлэл, сонсгол зэрэгт үндэслэн уг төслийг УХОХ-өөс хасах эсэх шийдвэрийг гаргана.

- 7.5. Төсөл хэвийн үргэлжилж байгаа буюу үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсхүл төсөл төлөвлөгөөний дагуу хэрэгжих эсэх нь эргэлзээтэй буюу дахин үнэлэх шаардлагатай гэсэн ангилалд орсон төслийн мэдээллийг шинэчлүүлж, "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах аргачлал" дахь Төслийн саналын маягтуудын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдаас гаргуулан авах ба тэрхүү шинэчлэгдсэн мэдээлэлд үндэслэн энэхүү аргачлалын дагуу төслийг дахин үнэлж, эрэмбэлнэ.

---oOo---



## ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас

| Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас |  |   |   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|---|--|---|---|------------|---|--|--|--|---|--|---|--|--|
| ТЭЗ:<br>Төслийн нэр:                      |  | <div style="border: 1px solid black; width: 100%; height: 20px; margin-bottom: 5px;"></div> <div style="border: 1px solid black; width: 100%; height: 20px;"></div> |   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
| №   | Бичиг баримт   | Бүрдэл  | ТЭЗ-ийн шалгасан байдал   | Тайлбар    | Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хянасан байдал |  |  |  |   |  |   |  |  |
| 1   | Төслийн товч танилцуулга   | Төслийн гол агуулга, ач холбогдол, төслийн хүрээнд хийгдэх болон хийгдсэн ажлуудыг багтаан танилцуулна.   |   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
| 2   | Төслийн судалгаануудын хураангуй   | Төсөл хөгжүүлэлтийн хүрээнд өмнө нь хийгдсэн судалгаануудын /суурь судалгаа, ТЭЗУС, ТЭЗҮ, БОНБУ г.м./ хураангуй танилцуулгыг 30 хүртэл хуудсанд багтаан бэлтгэнэ.   |   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
| 3   | Төслийн санал  | 1   | Хүснэгт. 1 Төслийн үндэсний мөдөөлөл  | Ж:бөглөсөн |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 2   | Хүснэгт. 2 Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин  |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 3   | Хүснэгт. 3 Санхүүжилт болон төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө  |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 4   | Хүснэгт. 4 Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 5   | Хүснэгт. 5 Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан байдал  |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 6   | Хүснэгт. 6 Төслийн дэд бүтцийн хэрэгцээ   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 7   | Хүснэгт. 7 Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ  |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 8   | Хүснэгт. 8 Санхүүгийн шинжилгээ <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; margin-top: 5px;"> <tr> <td style="width: 20px;"></td> <td>8-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Санхүүгийн шинжилгээ)</td> </tr> <tr> <td></td> <td>8-2. Зардлын задаргаа (Санхүүгийн шинжилгээ)</td> </tr> <tr> <td></td> <td>8-3. Зардлын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ)</td> </tr> <tr> <td></td> <td>8-4. Орлогын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ)</td> </tr> </table> |            | 8-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Санхүүгийн шинжилгээ)                |  | 8-2. Зардлын задаргаа (Санхүүгийн шинжилгээ)       |  | 8-3. Зардлын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ) |  | 8-4. Орлогын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ) |  |  |
|   |  |   | 8-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Санхүүгийн шинжилгээ)  |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  |   | 8-2. Зардлын задаргаа (Санхүүгийн шинжилгээ)  |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  |   | 8-3. Зардлын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ)   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  |   | 8-4. Орлогын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ)   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 9   | Хүснэгт. 9 Эдийн засгийн шинжилгээ <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; margin-top: 5px;"> <tr> <td style="width: 20px;"></td> <td>9-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Эдийн засгийн шинжилгээ)</td> </tr> <tr> <td></td> <td>9-2. Үр ашгийн тооцоолол (Эдийн засгийн шинжилгээ)</td> </tr> </table>   |            | 9-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Эдийн засгийн шинжилгээ)             |  | 9-2. Үр ашгийн тооцоолол (Эдийн засгийн шинжилгээ) |  |   |  |   |  |  |
|   |  |   | 9-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Эдийн засгийн шинжилгээ)   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   | 9-2. Үр ашгийн тооцоолол (Эдийн засгийн шинжилгээ)                                       |   |   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
| 10  | Хүснэгт. 10 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгт | Ж:бөглөөгүй   |   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
| 4   | Төслийн үнэлгээний дүгнэлт   | 1   | Урьдчилсан үнэлгээний хуудас  | Ж:бөглөсөн | Ж:дутуу нөхөн бүрдүүлэх   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 2   | Урьдчилсан үнэлгээний нэгдсэн дүгнэлт   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 3   | Төсвийн ерөнхийлөн захирагчийн иж бүрэн үнэлгээний хуудас   |            |   |  |  |  |   |  |   |  |  |
|   |  | 4   | Төслийн иж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлт  |            |   |  |  |  |   |  |   |  |  |

|  |                               |    |   |                |  |  |
|--|-------------------------------|----|---|----------------|--|--|
| 5  | Бусад судалгаа,<br>тооцоонууд | 1  | Суурь судалгаа  |                |  |  |
|  |                               | 2  | Бодлогын судалгаа   |                |  |  |
|  |                               | 3  | ТЭЗУС   | Ж: хавсаргасан |  |  |
|  |                               | 4  | ТЭЗҮ  |                |  |  |
|  |                               | 5  | Зураг төсөл   |                |  |  |
|  |                               | 6  | БОНБУ (өрөнхий)   |                |  |  |
|  |                               | 7  | БОНБУ (нарийвчилсан)  |                |  |  |
|  |                               | 8  | Газрын гэрчилгээ  |                |  |  |
|  |                               | 9  | Холбогдох тусгай зөвшөөрлүүд                                    |                |  |  |
|  |                               | 10 | Инженерийн судалгаа   |                |  |  |
|  |                               | 11 | Төслийн хүрээнд байгуулагдсан гэрээ,<br>хэлэлцээрийн хуулбар    |                |  |  |
|  |                               | 12 | Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө                              |                |  |  |
|  |                               | 13 | Эрсдлийн шинжилгээ  |                |  |  |
|  |                               | 14 | Мөнгөн урсгал / Санхүүгийн тайлан                               | Ж: хавсаргасан |  |  |
|  |                               | 15 | Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн<br>өгөөжийн дотоод хувь)       |                |  |  |
|  |                               | 16 | Эдийн засгийн шинжилгээ (Эдийн<br>засгийн өгөөжийн дотоод хувь) | Ж: Үгүй        |  |  |
| Үндэсний хөгжлийн асуудал<br>хариуцсан төрийн захиргааны<br>байгууллагын дүгнэлт |                               |    |   |                |  |  |

Хавсралт 2. Төслийн саналын маягтуудын мэдээлэл шаардлага хангаж буй эсэхийг нягтлах хуудас

| Төслийн саналын маягтуудын мэдээлэл шаардлага хангаж буй эсэхийг нягтлах хуудас |   |  |   |               |                           |         |
|---|---|--|---|---------------|---------------------------|---------|
| №   | Маягтын нэр   | Асуулт   |   | Бөглөсөн эсэх | Шаардлага хангаж буй эсэх | Тайлбар |
|   |   | Нэр  | Төрөл   |               |                           |         |
| 1   | Төслийн үндсэн мэдээлэл                                 | Төслийн нэр  |   | Ж: Лавлагаа   |                           |         |
|   |   | Төсөл хэрэгжих салбар  |   |               |                           |         |
|   |   | Төсөл хэрэгжих дэд салбар  |   |               |                           |         |
|   |   | Төсөл хэрэгжих байршил   |   |               |                           |         |
|   |   | Төслийн үндэслэл, шаардлага  |   |               |                           |         |
|   |   | Төслийн танилцуулга  |   |               |                           |         |
|   |   | Төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгууламж / тоног төхөөрөмж / үйл ажиллагаа |   |               |                           |         |
|   |   | Хөрөнгө оруулалтаар бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ                                | Бүтээгдэхүүн, үйлчилгээний агуулга, зах зээлийн өнөөгийн төлөв байдал |               |                           |         |
|   |   |  | Нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага                                    |               |                           |         |
|   |   |  | Эдийн засгийн эрэлт, хэрэгцээ, шаардлага                              |               |                           |         |
|   |   |  | Дэд бүтцийн хэрэгцээ, шаардлага                                       |               |                           |         |
|   |   | Бүтээн байгуулалтын зардлын эх үүсвэр  |   |               |                           |         |
|   |   | Төслийн нийт төсөвт өртөг  |   |               |                           |         |
|   |   | Төслийн болон ашиглалтын хүчин чадал   | Төслийн нийт хүчин чадал болон хэмжих нэгж                            |               |                           |         |
|   |   |  | Төлөвлөж буй ашиглалтын хүчин чадал                                   |               |                           |         |
|   |   | Төслийн хэрэгжих хугацаа   | Бүтээн байгуулалт   |               |                           |         |
|   |   |  | Ашиглалтанд орсноос хойш  |               |                           |         |
|   |   | Хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэх байдал                                   | Урт хугацааны хөгжлийн бодлого  |               |                           |         |
|   |   |  | 5 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлого                      |               |                           |         |
|   |   |  | 10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлого                     |               |                           |         |
|   |   |  | Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого                                    |               |                           |         |
| Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал                                       | УХОХ т тусгай бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал |  |   |               |                           |         |
|   | УХОХ-т тусгаагүй төсөл, арга хэмжээтэй уялдах байдал    |  |   |               |                           |         |
| Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө   | Хүрээлэн буй орчинд ээлтэй технологи                    |  |   |               |                           |         |
|   | Хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын тогтолцоо     |  |   |               |                           |         |
|   | Газар чөлөөлөлт   |  |   |               |                           |         |
| Төслийн зорилго, зорилт   | Эрхэм зорилго   |  |   |               |                           |         |
|   | Төслийн зорилго   |  |   |               |                           |         |
|   | Зорилт 1  |  |   |               |                           |         |
|   | Зорилт 2  |  |   |               |                           |         |
|   | Зорилт 3  |  |   |               |                           |         |
|   | Зорилт 4  |  |   |               |                           |         |
| Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд   | FIRR  |  |   |               |                           |         |
|   | Санхүүгийн өгөөжийн дотоод хувь                         |  |   |               |                           |         |

|   |  |  |  |  |  |
|---|--|--|--|--|--|
|   | NPV (Financial analysis)<br>Цэвэр өнөөгийн үнэ цэнэ<br>(Санхүүгийн)  |  |  |  |  |
|   | B/C<br>Үр ашиг, зардлын харьцаа<br>(Санхүүгийн)  |  |  |  |  |
|   | EIRR<br>Эдийн засгийн өгөөжийн<br>дотоод хувь  |  |  |  |  |
|   | NPV (Economic analysis)<br>Цэвэр өнөөгийн үнэ цэнэ<br>(Эдийн засгийн)  |  |  |  |  |
|   | B/C<br>Үр ашиг, зардлын харьцаа<br>(Эдийн засгийн)   |  |  |  |  |
| Төслийн нийгэм, эдийн<br>засгийн үр ашиг              | Төрөөс олон нийтэд үзүүлэх<br>үйлчилгээний стандартыг<br>сайжруулахад үзүүлэх нөлөө  |  |  |  |  |
|   | Хүний эрүүл, урт удаан<br>амьдрахад үзүүлэх нөлөө  |  |  |  |  |
|   | Иргэдийн мэдлэг, боловсролын<br>түвшинг дээшлүүлэхэд үзүүлэх<br>нөлөө  |  |  |  |  |
|   | Иргэдийн эрүүл, аюулгүй,<br>зохистой орчинд амьдрах<br>нөхцлийг бүрдүүлэхэд үзүүлэх<br>нөлөө   |  |  |  |  |
|   | Үндэсний үнэт зүйлийг<br>хадгалах, хамгаалах, бий<br>болгоход үзүүлэх нөлөө  |  |  |  |  |
|   | ЗҮАТ-нд дурдагдсан нийгмийн<br>ач холбогдлын үзүүлэлт нь<br>тухайн салбарын стандарт<br>түвшинг хангах эсэх                                |  |  |  |  |
| Эдийн засгийн үр<br>ашиг, хөрөнгө<br>оруулалтын өгөөж | Үндэсний үйлдвэрлэл,<br>үйлчилгээг нэмэгдүүлэхэд<br>үзүүлэх нөлөө  |  |  |  |  |
|   | Экспортыг дэмжих, импортыг<br>орлоход үзүүлэх нөлөө  |  |  |  |  |
|   | Ажлын байрыг нэмэгдүүлэхэд<br>үзүүлэх нөлөө  |  |  |  |  |
|   | Иргэдийн цалин, бодит орлогыг<br>нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө   |  |  |  |  |
|   | Гадаадын шууд хөрөнгө<br>оруулалтыг нэмэгдүүлэхэд<br>үзүүлэх нөлөө   |  |  |  |  |
|   | ЗҮАТ-нд дурдагдсан эдийн<br>засгийн үр ашиг, хөрөнгө<br>оруулалтын өгөөжийн үзүүлэлт<br>нь тухайн салбарын стандарт<br>түвшинг хангах эсэх |  |  |  |  |
| Хууль, эрх зүйн орчин                                 |  |  |  |  |  |
| Бүтэц, зохион байгуулалт                              |  |  |  |  |  |
| Шинэ технологи, инноваци шингэсэн байдал              |  |  |  |  |  |
| Холбогдох судалгаа, шинжилгээ                         |  |  |  |  |  |

|   |  |   |  |                    |  |  |  |
|---|--|---|--|--------------------|--|--|--|
|   |  | Дэд бүтцийн хэрэгцээ  |  |                    |  |  |  |
|   |  | Хэрэгжих боломж   |  |                    |  |  |  |
|   |  | Эрсдэл  |  |                    |  |  |  |
| 2 | Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин          | Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой нийцэх байдал                               | Урт хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал                                  | Ж: Ач холбогдол    |  |  |  |
|   |  |   | 10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал               |                    |  |  |  |
|   |  |   | 5 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал                |                    |  |  |  |
|   |  |   | Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал                              |                    |  |  |  |
|   |  | Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах уялдаа, хамаарал   | УХОХ-т туссан тухайн салбар, бүс орон нутаг дахь бусад төсөл, арга хэмжээтэй уялдах эсэх |                    |  |  |  |
|   |  |   | УХОХ-т тусаагүй тухайн салбар, бүс орон нутаг дахь төсөл, арга хэмжээтэй уялдах эсэх     |                    |  |  |  |
|   |  | Уялдан хэрэгжих ямар нэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байхгүй бол энэ тухай тодорхой тайлбарлах |  |                    |  |  |  |
|   | Төслийн үндэслэл, хууль эрх зүйн орчин         | Хууль эрх зүйн шаардлагад нийцэж буй байдал, төслийн үндэслэл                                   |  |                    |  |  |  |
| 3 | Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө | Бүтээн байгуулалтын үе шат  | Он оноор төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө                         | Ж: Хэрэгжих боломж |  |  |  |
|   |  |   | Төслийн бүтэц, зохион байгуулалтын бэлэн байдал  |                    |  |  |  |
|   |  |   | Шинэ технологи   |                    |  |  |  |
|   |  |   | Учирч болох эрсдэл   |                    |  |  |  |
|   |  |   | Эрсдэл бууруулах арга хэмжээ   |                    |  |  |  |
|   |  |   | Тоног төхөөрөмж  |                    |  |  |  |
|   |  |   | Барилга  |                    |  |  |  |
|   |  |   | Цалин хөлс   |                    |  |  |  |
|   |  |   | Бусад  |                    |  |  |  |
|   |  | Ашиглалтанд орсноос хойш  | Нийт   |                    |  |  |  |
|   |  |   | Төлөвлөж буй санхүүжилтийн хувь  |                    |  |  |  |
|   |  |   | Он оноор төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө                         |                    |  |  |  |
|   |  |   | Учирч болох эрсдэл   |                    |  |  |  |
|   |  |   | Эрсдэл бууруулах арга хэмжээ   |                    |  |  |  |
|   |  |   | Тоног төхөөрөмж  |                    |  |  |  |
|   |  |   | Барилга  |                    |  |  |  |
|   |  |   | Цалин хөлс   |                    |  |  |  |
|   |  |   | Бусад  |                    |  |  |  |
|   |  | Нийт  |  |                    |  |  |  |
|   |  | Төслийн хүрээнд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ   |  |                    |  |  |  |
| 4 |  | Зорилтууд   |  |                    |  |  |  |

|  |   |  |                                      |                            |   |  |  |  |
|--|---|--|--------------------------------------|----------------------------|---|--|--|--|
|  | Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт    | Шалгуур үзүүлэлтийн түвшин   |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Үнэлэх шалгуур үзүүлэлтийн нэр   |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Тайлбар  |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Суурь түвшин, өмнөх оны хэрэгжилт  |                                      |                            |   |  |  |  |
| 5  | Төслийн урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл | Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн   |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Суурь судалгаа   |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Бодлогын судалгаа  |                                      |                            |   |  |  |  |
|  |   | ТЭЗУС  |                                      |                            |   |  |  |  |
|  |   | ТЭЗҮ   |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Зураг төсөл  |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Байгаль орчны ерөнхий/нарийвчилсан үнэлгээ   |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Газрын асуудал шийдэгдсэн эсэх   |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Холбогдох тусгай зөвшөөрлүүд   |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Бусад  |                                      |                            |   |  |  |  |
| Байгуулсан гэрээ, хэлэлцээр                              |   |  |                                      |                            |   |  |  |  |
| 6  | Төслийн дэд бүтцийн хэрэгцээ              | Дэд бүтэц  |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Хэмжих нэгж  |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Нийт хэрэгцээ  |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Одоогийн байдал  |                                      |                            |   |  |  |  |
|  |   | Өргөтгөх/Шинээр барих  |                                      |                            |   |  |  |  |
